

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай аймаг, нийслэлийн Засаг дарга нарын Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг дүгнэсэн тухай

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай аймгуудын Засаг дарга нар болон Улаанбаатар хотын захирагч, нийслэлийн Засаг даргын байгуулсан 2022 оны хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх, зөвлөмж өгөх зорилготой ажиллав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг удирдлага болгон, 2022 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан 21 аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн гэрээний үүргийн биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгөв.

Гурав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хугацаа

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/548 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, 21 аймаг, нийслэлийн Засаг даргын 2022 онд хийсэн ажил, гэрээний үүргийн биелэлтэд чиглэл бүрээр үнэлэлт, дүгнэлт гарган, хяналт шинжилгээ үнэлгээ хийв.

Дөрөв. Тайлант хугацааны ажлын гүйцэтгэл

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний биелэлт жилийн эцсийн байдлаар ерөнхий гүйцэтгэл 91.3 хувьтай, өмнөх онтой харьцуулахад 7.8 хувийн өсөлттэй дүгнэгдэв.

2022 оны гэрээний биелэлтийн дүнгээс харахад 21 аймаг, нийслэлийн гэрээний биелэлтийг 91.0%-95.11% /А буюу маш сайн/ үнэлгээтэй, 5 аймаг 80.6%-89.3% /В буюу сайн/ үнэлгээтэй, 16 аймаг 78.5% /С буюу хангалттай/ гэсэн үнэлгээтэй, 1 аймаг байна. (1 дүгээр хавсралт)

Нийслэл, 21 аймгийн гэрээнд заасан нийт 1,295 арга хэмжээнээс 65 арга хэмжээ буюу 5.01 хувь нь хэрэгжээгүй байна.

Гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хэрэгжүүлсэн:

Сэлэнгэ аймаг гэрээнд тусгасан 59 арга хэмжээнээс 49 арга хэмжээг 100 %-тай, 1 арга хэмжээг 90%-тай, 3 арга хэмжээг 70 %-тай, 5 арга хэмжээг 50%-тай, 1 арга хэмжээ 30%-тай 95.1%-иар үнэлэгдсэн бол хамгийн бага үнэлгээтэй Архангай гэрээнд тусгасан 54 арга хэмжээнээс 19 арга хэмжээг 100%, 5 арга хэмжээг 90%-тай% 7 арга хэмжээг 70%-тай, 9 арга хэмжээг 50%-тай, 8 арга хэмжээг 30%-тай, Үнэлэх боломжгүй 6 арга хэмжээ тус тус хэрэгжүүлж 78.5%-тай үнэлэгдсэн байна.

Гэрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах талаар зорилтын хүрээнд Дархан-Уул, Өмнөговь, Орхон аймгууд арга хэмжээ огт төлөвлөөгүй: Гэрээнд тусгагдсан арга хэмжээг огт тайлагнаагүй:

Хөвсгөл аймаг Бүх нийтээр мод тарих аяныг зохион байгуулж тарьсан модны арчилгаа хамгаалалтын арга хэмжээг иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр гүйцэтгэх ажлыг зохион байгуулах, тайлагнах арга хэмжээ;

Гэрээний биелэлтэд Сайдын багцын улсын төсвийн санхүүжилтээр хийгдсэн арга хэмжээнд аймгийн Засаг даргын зүгээс тавигдаж буй хяналт, хамтран оролцох талаар хангалтгүй тайлагнасан байна.

Тав. Дүгнэлт

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг ажлын хэсгээс дүгнэж, жилийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг хүргүүлж байна.

-Хамтран ажиллах гэрээний зорилт арга хэмжээ болон хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг оновчтой төлөвлөөгүй, хамтран ажиллах гэрээнд мэдээ тайлан ирүүлэх, сургалт зохион байгуулах зэрэг шаардлагагүй арга хэмжээ төлөвлөсөн.

-Гэрээнд тусгасан арга хэмжээний биелэлтийг оновчтой, товч тодорхой (тоо, хугацаа, чанар) нотлогдохуйц бичээгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хүрэх үр дүн тодорхойгүйгээс зорилтот түвшинд хүрээгүй, төлөвлөлтөө ойлгоогүйгээс биелэлтийг зөрүүтэй тайлагнасан, үр дүнг бус үйл явц, мэдээлэл бичсэн, зарим арга хэмжээний биелэлтийг бичиж ирүүлээгүй орхигдуулсан.

-Гэрээний үүргийн биелэлт нь баримт бичгийн боловсруулалт хангалтгүй, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар болон баримт бичгийн стандартын шаардлага хангаагүй, утга агуулга нь тодорхой бус, логик дэс дараалалгүй, үг, үсгийн болон хэл найруулгын алдаатай, хуудсыг дугаарлаагүй, ар өвөргүй хэвлэсэн зэрэг нийтлэг зөрчил илэрсэн болно.

-Гэрээнд тусгагдсан 9 зорилтын хүрээнд аймаг бүр 38-77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан, зорилт, арга хэмжээг оновчтой зөв тодорхойлоогүй, арга хэмжээний хүрэх үр дүнг тоо чанарын үзүүлэлтээр тодорхойлоогүй, нэг зорилтын дор агуулга давхацсан арга хэмжээг ажил болгож оруулсан гэрээнд тусгагдсан арга хэмжээг огт тайлагнаагүй, үр дүнг өмнөх түвшинтэй харьцуулж дүгнээгүй, давхардуулан тайлагнасан байна.

Цаашид гэрээ байгуулах гэрээний зорилт тус бүрээр чиг үүргийн дагуу бүх газраас санал авч баталгаажуулсаны дараа гэрээг сайдаар баталгаажуулах;

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймгийн Засаг дарга, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги, Тусгай хамгаалалттай газар, Сав газрын захиргаа, бусад байгууллагатай хамтарч хууль тогтоомжийг үндэслэн холбогдох асуудлуудын хүрээнд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулж, хамтарч ажиллах, арга хэмжээний гүйцэтгэлд анхаарч, хэрэгжилтийг үнэн зөв тайлагнах шаардлагатай гэж дүгнэв.

Зөвлөмж

Төрийн захиргааны удирдлагын газар болон бүх газруудад:

-2023 оны хамтран ажиллах гэрээнд аймгийн Засаг дарга нар байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн талаар хууль, бодлого, хөтөлбөрт тусгасан зорилтыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээг заавал тусгах;

-Тухайн зорилт, арга хэмжээг зөв тодорхойлох (хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй, хэт ерөнхий байдлаар төлөвлөснөөс гарах үр дүн тодорхойгүй, дүгнэх боломжгүй байдгийг анхаарах);

-Суурь үзүүлэлт (он, түвшин)-ийг заавал, арга хэмжээний тоон болон чанарын үзүүлэлтийг харьцуулагдахаар тодорхой тусгаж өгөх;

- Бүх газрууд санал өгч баталгаажуулсны дараа гэрээнд зорилт арга хэмжээг тусгах;

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулах гэрээнд “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг гүйцэтгэлийн талаар гэрээний биелэлтэд мөнгөн дүн болон % хувиар илэрхийлэн тусгах;

-Тайлагнах мөнгөн хангаж ажиллах, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв бодитоор тайлагнах талаар заалт оруулах;

-Хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, үйл ажиллагааг орон нутгийн Засаг захиргаа, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах

-Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарах;

-Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг хүнээр тооцох;

-Байгаль орчны статистик мэдээллийг анхан шатанд зөв үнэн бодиттой байдлаар гаргах;

-2022 онд БОАЖС болон Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран баталсан агаарын чанарыг сайжруулах бүсэд журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

-Улсын чанартай авто болон төмөр замын бүтээн байгуулалтад ашиглаж буй түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, олборлолт нөхөн сэргээлтэд байнгын хяналт тавих;

-Агнуурын бүсийг орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоохдоо холбогдох хууль журмын хүрээнд шинжлэх ухааны судалгааны тоон үзүүлэлтүүдийг үндэслэн тогтоох;

-Тусгай зориулалтын ангийн менежмент хариуцагч нарын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, хамтран ажиллах

-Зэрлэг амьтан хамгааллын хууль бус ашиглалтын талаар Олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах

-Зэрлэг амьтан хамгааллын хууль бус ашиглалтын талаар сургалт соён гэгээрүүлэх ажлуудыг үе шаттай зохион байгуулах

- Нэг ажлын тайланг нөгөө ажил дээр давхцуулж тайлагнахгүй байх;

- Усны ашиглалт, хэрэглээг тоолууржуулах ажлын тайланг ирүүлэхдээ нийт зарцуулсан хөрөнгийн дүн, хөрөнгийн эх үүсвэр, гүйцэтгэгчийн талаарх мэдээллийг заавал тайлагнах;

- Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасны дагуу усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг ИТХ-аар тогтоож, Хууль зүйн яаманд бүртгүүлж, дэглэмийг мөрдүүлж, тэмдэгжүүлэх, хэрэгжүүлэх, сурталчилан таниулах арга хэмжээг заавал тусгах;

-Төлөвлөгдсөн арга хэмжээний дагуу биелэлтийг нотлох баримтыг хавсаргах;

-Гэрээний биелэлтийг тайлагнахдаа үг үсгийн алдаагүй 2000 тэмдэгтэд багтаах, архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцүүлэх шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:

САЙД  Б.БАТ-ЭРДЭНЭ

2022 оны 12 дугаар сарын-ны өдөр

ТӨРИЙН НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА  О.БАТТУЛГА

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ГАЗРЫН ДАРГА  В.ЖАВЗАН

2022 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА  Т.ГОЦБАЯР

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

ГИШҮҮД:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН

НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН  А.ОЮУН

2022 оны 12 дугаар сарын-ны өдөр

ОЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАГДАГ

2022 оны 12 дугаар сарын-ны өдөр

УСНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН  Т.ДАВААНЯМ

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН  Б.ЖАВХЛАН

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТНИЙ АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *О. Мөнхцэцэг* О.МӨНХЦЭЦЭГ

2022 оны 12 дугаар сарын *23*-ны өдөр

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН *ЖС* Ж.ДӨЛГӨӨН
2022 оны 12 дугаар сарын *23*-ны өдөр